



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/35/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Саранчимэг

Утас: 70273204 Цахим хаяг: tsaranchimeg@audit.gov.mn

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа	16
4.4 Зөвлөмж	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272248, Факс: 70272582, Имэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/69
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ
19020266

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	44,040,764.00	43,103,330.00
33	АВЛАГА	6,400.00	761,536.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	761,536.00
35	БАРАА МАТЕРИАЛ	44,034,364.00	42,341,794.00
351	Түүхий эд материал	5,250,000.00	4,800,000.00
35110	Тусгай зориулалттай материал	5,250,000.00	4,800,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	32,520,744.00	31,821,154.00
354	Хангамжийн материал	6,263,620.00	5,720,640.00
35410	Бичиг хэргийн материал	61,820.00	18,440.00
35420	Аж ахуйн материал	184,900.00	341,100.00
35470	Бусад хангамжийн материал	6,016,900.00	5,361,100.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	217,376,436.46	168,966,866.85
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	217,376,436.46	168,966,866.85
392	Биет хөрөнгө	141,301,951.45	104,526,961.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	12,813,000.09	2,290,740.09
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,864,681.56	-477,237.60
39203	Авто-тээврийн хэрэгсэл	250,605,505.00	156,116,505.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-146,938,838.48	-75,483,171.88
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	84,403,768.00	61,321,938.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-63,961,154.75	-44,431,761.46
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,857,336.00	12,254,526.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-8,612,982.85	-7,064,576.35
39214	Бусад үндсэн хөрөнгө	88,111,505.34	28,146,911.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	-88,111,505.34	-28,146,911.60
393	Биет бус хөрөнгө	76,074,485.01	64,439,905.05
39301	Програм хангамж	570,000.00	570,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-308,749.99	-363,749.95
39303	Бусад биет бус хөрөнгө	116,520,800.00	116,520,800.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-40,707,565.00	-52,287,145.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	261,417,200.46	212,070,196.85
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	157,875.01	892,096.01
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	157,875.01	892,096.01
413	Өглөг	157,875.01	892,096.01
41310	Ажилгчидтай холбогдсон өглөг	00.00	85.00
4136	Бусад өглөг	157,875.01	892,011.01
41361	Байгууллагад төлөх өглөг	157,875.01	892,011.01
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	261,259,325.45	211,178,100.84
51	Засгийн газрын хувь оролцоо	261,259,325.45	211,178,100.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	85,413,307.00	85,413,307.00
51101	Өмч: - төрийн	84,688,307.00	84,688,307.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	725,000.00	725,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	166,033,017.80	125,317,664.48
51210	Өмнөх үеийн үр дүн	166,033,017.80	175,398,889.09
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-50,081,224.61
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,813,000.65	447,129.36
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	261,417,200.46	212,070,196.85

Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	632,520,748.80	526,696,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	31,096,948.80	50,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	31,096,948.80	50,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	31,000,000.00	50,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	31,000,000.00	50,000.00
120009	Бусад орлого	96,948.80	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	601,423,800.00	526,646,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,650,000.00	2,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,100,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт	3,550,000.00	2,300,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	555,773,800.00	524,346,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	555,773,800.00	524,346,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	591,381,847.65	576,728,124.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	591,381,847.65	576,728,124.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	544,496,998.85	574,228,064.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	431,556,197.00	443,465,270.00
210101	Үндсэн цалин	431,556,197.00	443,465,270.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,130,762.75	58,734,715.00
210201	Тэтгэврийн даатгал	38,110,282.75	41,276,346.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,278,880.00	4,585,853.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,397,800.00	3,547,722.00
210204	Ажилгүйдлийн даатгал	849,400.00	847,706.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,494,400.00	8,477,088.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	628,400.00	628,300.00
210304	Байрны түрээс	628,400.00	628,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,259,640.00	11,475,080.00
210401	Бичиг хэрэг	1,226,340.00	1,474,830.00
210402	Тээвэр, шатахуун	7,159,000.00	6,308,800.00
210403	Шуудан, холбоо, интэрнэтийн төлбөр	1,477,450.00	1,335,380.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	396,850.00	492,080.00
210408	Бараа материал актальсны зардал	00.00	1,863,990.00
2105	Нормативт зардал	1,210,600.00	287,990.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,210,600.00	287,990.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,206,850.00	3,106,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	205,000.00	00.00
210604	Урсгал засвар	5,001,850.00	3,106,700.00
2107	Томилолт, зочны зардал	3,303,000.00	5,154,500.00
210702	Дотоод албан томилолт	3,303,000.00	5,154,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,994,600.00	1,500,940.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,047,300.00	459,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	322,900.00	477,640.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	192,400.00	131,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,206,949.10	49,874,569.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,775,600.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	655,500.00	750,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	30,775,849.10	49,124,569.61
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,884,848.80	2,500,060.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,540,700.00	2,500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	39,540,700.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	2,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,344,148.80	00.00
213304	Хөрөнгийн	4,344,148.80	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,	00.00	60.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	60.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	41,138,901.15	-50,031,224.61
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	50,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	50,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-50,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	41,138,901.15	-50,081,224.61

Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /						
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	85,413,307.00	9,813,000.65	164,894,116.65	00.00	260,120,424.30
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	85,413,307.00	9,813,000.65	164,894,116.65	00.00	260,120,424.30
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	41,138,901.15	00.00	41,138,901.15
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	85,413,307.00	9,813,000.65	166,033,017.80	00.00	261,259,325.45
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	85,413,307.00	9,813,000.65	166,033,017.80	00.00	261,259,325.45
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	9,365,871.29	00.00	9,365,871.29
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	85,413,307.00	9,813,000.65	175,398,889.09	00.00	270,625,196.74
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-9,365,871.29	00.00	00.00	-9,365,871.29
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	-50,081,224.61	00.00	-50,081,224.61
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	85,413,307.00	447,129.36	125,317,664.48	00.00	211,178,100.84

Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	601,520,748.80	526,646,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	96,948.80	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	96,948.80	00.00
120009	Бусад орлого	96,948.80	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	601,423,800.00	526,646,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,650,000.00	2,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод	42,100,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий	3,550,000.00	2,300,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	555,773,800.00	524,346,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	555,773,800.00	524,346,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	556,901,600.00	525,931,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	556,901,600.00	525,931,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	514,360,900.00	523,431,840.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	428,908,100.00	446,399,900.00
210101	Үндсэн цалин	354,715,689.29	332,802,657.21
210102	Нэмэгдэл	57,062,441.71	85,537,242.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,129,969.00	23,681,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	4,379,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,626,400.00	55,800,000.00
210201	Тэтгэврийн даатгал	36,637,600.00	37,944,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,247,200.00	4,464,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,397,800.00	3,571,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	849,400.00	892,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,494,400.00	8,928,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	628,400.00	628,300.00
210304	Байрны түрээс	628,400.00	628,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,592,450.00	9,723,910.00
210401	Бичиг хэрэг	1,283,200.00	1,497,450.00
210402	Тээвэр, шатахуун	7,159,000.00	6,308,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,477,450.00	1,335,380.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	672,800.00	582,280.00
2105	Нормативт зардал	1,210,600.00	367,890.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,210,600.00	367,890.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,304,750.00	3,106,700.00
210604	Урсгал засвар	5,001,850.00	3,106,700.00
2107	Томилолт, зочны зардал	3,303,000.00	5,154,500.00
210702	Дотоод албан томилолт	3,303,000.00	5,154,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,099,600.00	1,500,640.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,047,300.00	459,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	322,900.00	477,640.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	192,400.00	131,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,687,600.00	750,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,787,600.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	900,000.00	750,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,540,700.00	2,500,060.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,540,700.00	2,500,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	39,540,700.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	2,500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох	00.00	60.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,344,148.80	60.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	275,000.00	715,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	275,000.00	715,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	275,000.00	715,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	275,000.00	715,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	275,000.00	715,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР	-275,000.00	-715,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Баглагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Баглагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	460,765,500.00	460,765,500.00	524,346,900.00	524,346,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	460,765,500.00	460,765,500.00	524,346,900.00	524,346,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	445,406,100.00	445,406,100.00	521,846,900.00	521,846,840.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	366,314,300.00	366,314,300.00	446,399,900.00	446,399,900.00
210101	Үндсэн цалин	306,959,200.00	306,959,200.00	368,751,100.00	332,802,657.21
210102	Нэмэгдэл	48,003,100.00	48,003,100.00	61,917,800.00	85,537,242.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,352,000.00	11,352,000.00	11,352,000.00	23,681,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00	4,379,000.00	4,379,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,218,300.00	46,218,300.00	55,800,000.00	55,800,000.00
210201	Тэтгэврийн даатгал	31,136,700.00	31,136,700.00	37,944,000.00	37,944,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,663,100.00	3,663,100.00	4,464,000.00	4,464,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,930,500.00	2,930,500.00	3,571,200.00	3,571,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,161,700.00	1,161,700.00	892,800.00	892,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,326,300.00	7,326,300.00	8,928,000.00	8,928,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	627,500.00	627,500.00	1,416,600.00	628,300.00
210304	Байрны түрээс	627,500.00	627,500.00	1,416,600.00	628,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,521,100.00	9,521,100.00	9,401,100.00	9,033,900.00
210401	Бичиг хэрэг	1,043,200.00	1,065,065.67	1,369,300.00	1,002,100.00
210402	Тээвэр, шатахуун	7,322,300.00	7,282,061.93	6,308,800.00	6,308,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	886,300.00	956,353.00	1,298,600.00	1,298,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	269,300.00	217,620.00	424,400.00	424,400.00
2105	Нормативт зардал	5,435,600.00	5,435,600.00	352,000.00	352,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,435,600.00	5,435,600.00	352,000.00	352,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,942,900.00	3,942,900.00	2,779,100.00	3,379,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,802,900.00	1,802,900.00	352,400.00	352,400.00
210604	Урсгал засвар	2,140,000.00	2,140,000.00	2,426,700.00	3,026,700.00
2107	Томилолт, зочны зардал	4,851,100.00	4,851,100.00	3,234,100.00	4,003,000.00
210702	Дотоод албан томилолт	4,851,100.00	4,851,100.00	3,234,100.00	4,003,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	6,095,300.00	6,095,300.00	1,714,100.00	1,500,640.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	320,000.00	320,000.00	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	395,100.00	395,100.00	538,900.00	459,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	319,800.00	319,800.00	512,800.00	477,640.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	134,000.00	134,000.00	230,400.00	131,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,400,000.00	2,400,000.00	750,000.00	750,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	900,000.00	900,000.00	750,000.00	750,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,359,400.00	15,359,400.00	2,500,000.00	2,500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,359,400.00	15,359,400.00	2,500,000.00	2,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,500,000.00	2,500,000.00	2,500,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	460,765,500.00	460,765,500.00	524,346,900.00	524,346,900.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	460,765,500.00	460,765,500.00	524,346,900.00	524,346,900.00
132001	Орон нутгийн төсвөөс	460,765,500.00	460,765,500.00	524,346,900.00	524,346,900.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	48	48	48	45
620001	Удирдах ажилтан	1	1	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	43	43	43	40
620003	Үйлчлэх ажилтан	4	4	4	4

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,650,000.00	2,300,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,650,000.00	2,300,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,650,000.00	2,300,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	611,150.00	690,010.00
210401	Бичиг хэрэг	220,000.00	495,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	391,150.00	36,780.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	157,880.00
2105	Нормативт зардал	-	15,890.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	15,890.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	816,850.00	442,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	362,600.00
210604	Урсгал засвар	816,850.00	80,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	1,151,500.00
210702	Дотоод албан томилолт	-	1,151,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	648,400.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	586,900.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,100.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	58,400.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,573,600.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,573,600.00	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	45,746,948.80	2,300,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,746,948.80	2,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	42,100,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,550,000.00	2,300,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой анхан шатны баримтын бүрдүүлэлт болох е баримт, дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн №07/13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн хандлагыг экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байхад чиглүүлж, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалж, ногоон хөгжлийг хангах үйл ажиллагаанд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг өрнүүлж хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах замаар аймгийн Засаг даргад цаг үеийн мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэгийг үзүүлэх чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн байгууллага юм.

Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын 2020 оны А/49 тоот тушаалаар дотоод хяналт шалгалт явуулах ажлын хэсгийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, хяналт шалгалт зохион байгуулах журмыг хавсралтаар баталж ажилдаа мөрдлөг болгон ажилласан байна. Дотоод хяналт шалгалтын 12 ажил төлөвлөснөөс гүйцэтгэлээр 12 ажлыг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 оны 01 дүгээр сарын 6-аас 02 дугаар сарын 1-ны хооронд 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд, 12 сард Аймгийн Засаг даргын үзлэг тус тус хяналт шалгалт хийсэн байна.

Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшин 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 632,520.7 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 9,487.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75,0 хувиар буюу 7,115.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын төлөвлөх үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн

мэдээллээр тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос дахин тооцлоо.

Гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоосон материаллаг байдлын түвшин 7,900.5 мянган төгрөг, энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 1,587.3 мянган төгрөгөөр буурсан байна. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 5,925.4 мянган төгрөгөөр тогтоогдсон байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Энэхүү Санхүүгийн тайлангаар Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккреул сууриар бэлтгэн тайлагнасан байна.

Орлого:

Тус байгууллага 2021 онд улсын төсвөөс 524,346.9 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 2,300.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 50.0 мянган төгрөг, нийт 526,696.9 мянган төгрөг өмнөх оноос 105,823.8 мянган төгрөгөөр буюу 16,7 хувиар буурсан байна.

Зардал:

Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 576,728.1 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 525,931.9 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 521,846.9 мянган төгрөг зарцуулсан байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:

Тус байгууллага төрийн сангийн 100140013001 тоот дансанд 2021 онд 524,346.9 мянган төгрөгийн орлого, 524346.8 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Мөн нэмэлт санхүүжилтийн 100140013402 тоот дансанд 2,300.0 мянган төгрөгийн орлого төвлөрч, 2,300.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 0 төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	6.4	761.5	755.1
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	44,034.4	42,341.8	(1,692.6)
Нөөцийн бараа /сурах бичиг/	-	-	-
Үндсэн хөрөнгө	217,376.4	168,966.9	(48,409.5)
Нийт хөрөнгө	261,417.2	212,070.2	(49,347.0)
Өр төлбөр	157.9	892.1	734.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	261,259.3	211,178.1	(50,081.2)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	261,417.2	212,070.2	(49,347.0)

Авлагын дансны үлдэгдэл 761.5 мянган төгрөг болж 755.1 мянган төгрөгөөр өссөн нь Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2019-2020 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхэд илэрсэн төлбөрийн актын авлага нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 42,341.8 мянган төгрөг болж 1,692.6 мянган төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын материал 450.0 мянган төгрөгөөр, бэлэн бүтээгдэхүүн 699.6 мянган төгрөг, бусад хангамжийн материал 655.8 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 168,966.9 мянган төгрөг болж 48,409.5 мянган төгрөгөөр буурсан нь Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 62 тоот тогтоолоор 22,232.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгө 45,082.2 мянган төгрөг, 2,273.8 мянган төгрөгийн тавилга эд хогшил акталж, 10,522.3 мянган төгрөгийн барилга байгууламж, 32,382.4 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 1,564.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж шилжүүлэх шийдвэрийн дагуу данснаас хассанаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 211,178.1 мянган төгрөг болж 50,081.2 мянган төгрөгөөр буурсан нь дахин үнэлэгдсэн хөрөнгө данснаас хасагдсан болон тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 620,623.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 620,623.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 96,2769.5 мянган төгрөгөөр бууруулж орон нутгийн төсвөөс 521,846.9 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан

байна. Энэ нь цалин, шимтгэл 52,658.2 мянган төгрөгөөр зардлыг бууруулсантай холбоотой байна. Мөн Сангийн сайдын 43 дугаар тогтоолтой холбоотойгоор бараа үйлчилгээний бусад зардал 5,019.6 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардал 11,400.9 мянган төгрөг, томилолтын зардал 2,287.4 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 9,386.6 мянган төгрөг, норматив зардал 5,168.0 мянган төгрөг, харуул хамгаалалтын зардал 6,807.8 мянган төгрөгөөр тус тус бууруулан баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 32 арга хэмжээг санхүүжүүлэхээр 521,846.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 521,846.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 521,846.9 мянган төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 521,846.9 мянган төгрөгийг зарцуулж, 0.06 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 521846.9 мянган төгрөг буюу 100.0 хувь зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь нийт 2,300.0 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлсэн байна.

Үүнээс хангамж, бараа материалын зардалд 690.0 мянган төгрөг, норматив зардал 15.9 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардал 442.6 мянган төгрөг томилолт 1,151.5 мянган төгрөг, нийт 2,300.0 мянган төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байхгүй

3.8 Аудитын гол асуудал

Төв аймгийн Байгаль орчин аялал, жуулчлалын газар 524,346.9 мянган төгрөгийн төсвийн зарцуулалтаас 95,8% буюу 502,199.9 мянган төгрөг нь цалин, Аудитын код ТӨА-2022/35/-НА-СТА-ТШЗ

шимтгэлийн зардал эзэлж байна. Бусад зардал нийт зардлын 4,2% буюу 22,147.0 мянган төгрөгийг эзэлж байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 148 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 1 байна. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг бүрэн байршуулсан эсэхийг шалгасан. Мэдээллийг бүрэн оруулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь нэмэлт санхүүжилтийн дансаар зарцуулсан 2,300.0 мянган төгрөгийг бусад хууль тогтоомжийн хүрээнд зарцуулан тайлагнасан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны мэдээллийг бүрэн оруулах, албан журмын даатгалын хураамжийг даатгуулагчаар төлүүлэх 2 зөвлөмжийг 100.0% хэрэгжүүлэн ажиллаж Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 07/158 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шатахууны тооцоо бодолтыг шалгах

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 75,779.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, материаллаг 75,779.9 мянган төгрөгийн алдааг залруулсан.

4.1 Залруулсан алдаа

Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайланд үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 75,779.9 мянган төгрөгөөр илүү тооцож тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.1 Төлбөрийн акт

Байхгүй

4.2 Албан шаардлага

Байхгүй

4.4 Зөвлөмж

Байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар	1	75,779.9	1	75,779.9	0	0	0	0	0	0